

Чингис хааны мэргэн ухаан

Wisdom of Chinggis Khaan

Батын Ч.Ган-Өлзий¹

*Доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Философийн салбар
ganulziich@mas.ac.mn*

Gan-Ulzii Ch. Batyn

*Doctor (Sc.D), professor
Department of Philosophy,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
ganulziich@mas.ac.mn*

Хураангуй:

Философийг шинжлэх ухаануудаас өөрөөр нэг талаас, далдын хүч, ид шидийн итгэл үнэмшил (magic), агийн ёс (mysticism)-ны санаалаг юмс нөгөө талаас, амьдрах ертөнцийн бодит материаллаг туршлагатай шүтэн барилдуулж урьдах ухаан, урьдаас мэдрэх зөн билиг, сэтгэл хөдлөлийн хүч, утгын тайлал, мэдэгдэхүүний билгийн ухаарлын чинад эргэн хянах арга зүй болгон ашиглаж байгаад судалгааны шинэлэг тал оршино.

Түлхүүр үгс: мэргэн ухаан, сэцлэх, мэдэгдэхүүн, бичиг, урьдах, найраг

Abstract:

Philosophy differs from the sciences, on the one hand, by hidden power, magical beliefs (magic), and on the other hand, the ideas of mysticism, and on the other hand, the real material experience of the living world is worshipped with foresight, intuition, emotional power and meaning. The article states that during the reign of Genghis Khagan, philosophy was formed in a form close to European, in terms of the content of naturalistic nomadic life wisdom. Genghis Hagan could...

Keywords: wisdom, philosophizing, phenomenon, writing, prejudice, poetry

I. Оршил

Энэ бол өрнө дахинаа 1500 гаруй жил философи гэж нэрлэн ирсэн мэргэн ухаан XIII зууны үед монголчууд сэргэн мандах цагт хэдийн боловсорсон байсан бөгөөд түүнийг Чингис хаан үйл ажиллагаандаа сайтар ашигладаг байсан гэдгийг батлах зорилготой судалгаа юм. Одоо цагт мэргэн ухаанд дурлах гэсэн утгатай философийг хүмүүс улам илүү оюун билигтэй болж, өөрийгөө сайтар танин мэдсэнээр тусгай онцгой зүйлийн чинадаас ерөнхий зүй тогтлыг олж гаргах чадварыг эзэмших зорилгоор бодол эргэцүүлэл, үнэлэлт дүгнэлт ба үйл

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

байдлынхаа арга барилыг нарийн чанд, бүтээлч шүүмжлэлтэйгээр шинжлэн судлах явдал гэж ойлгох болсон. XIII зууны эхэн үеийн уран зохиол, яруу найраг ба соёлын артефактын өөрийн уг чанар, үнэн утгын суурь үндэслэгээг эргүүлэн ухааж, туршиж олох, асуулт тавих, егөөдөн мэтгэлцэх замаар харилцан ярилцах, хэлэлцэн дүгнэх арга хэрэглэн Чингис хааны өөрөө тодрох гоц чанарын чинадаас нүүдэлчин монголчуудын хөгжлийн ерөнхий зүй тогтлыг илрүүлэх философийн зорилго нь цоо шинэ, тулгамдсан шаардлага болж байна.

Сэтгэлгээ ба үйл ажиллагааныхаа шударга үнэн суурь зарчмуудыг ухаарч ойлгож чадахгүй байгааг нь хүмүүст өөрт нь ухамсарлуулах, тэднийг философийн мэргэн ухааны зөв замд чиглүүлэн урин дуудаж, өдөөн түлхэж өгдөг монгол мэргэн ухааныг өмнө нь ер судлаж байсангүй. Философийг шинжлэх ухаануудаас өөрөөр нэг талаас, далдын хүч, ид шидийн итгэл үнэмшил (magic), агийн ёс (mysticism)-ны санаалаг юмс нөгөө талаас, амьдрах ертөнцийн бодит материаллаг туршлагатай шүтэн барилдуулж урьдах ухаан, урьдаас мэдрэх зөн билиг, сэтгэл хөдлөлийн хүч, утгын тайлал, мэдэгдэхүүний билгийн ухаарлын чинад эргэн хянах арга зүй болгон ашиглаж байгаад судалгааны шинэлэг тал оршино. Үүний тулд Чингис хааны амьд ахуйд бичигдэн үлдсэн уран зохиол, яруу найраг ба соёлын артефактууд дахь мэргэн ухааны өв уламжлалыг орчин үеийн философийн тэргүүлэх хандлага болсон тайлал зүйн мэдэгдэхүүний билиг(Hermeneutische Phänomenologie)-ын үүднээс шинээр ойлгох судалгааны зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр философи гэж нэрлэгддэг мэргэн ухаан XIII зууны эхэнд монгол нүүдэлчдийн оюун санааны өөрийн ухамсар, Чингис хааны сэтгэлгээний арга нэгэнт болж чадсан байсан гэсэн таамаглалыг батлах учиртай юм.

II. Судалгааны арга зүй

Өнгөрсөн дөрвөн зууны турш эпистемологийн хоёр гол онол байж ирсэн эмпиризм ба рационализмын дутагдлыг ер гаргадаггүй бөгөөд тэнгэр, байгаль ба хүний ертөнцийг шүтэн барилдуулж тайлах Үнэн мөн ба шударга, сайн үйлийн зарчмуудыг үндэсний өв уламжлал, эртний мэргэн ухаанд тулгуурлан байнга, алхам алхмаар, улам гүнзгий мэдэж авахад тус болдог асуулт хариултын үйл явцыг задлан шинжлэх философийн тайлал зүйн мэдэгдэхүүний билиг буюу герман хэлээр “*Hermeneutische Phänomenologie*” гэж нэрлэгддэг херменойтик арга зүй, феномэнологийг хэрэглэсэн болно.

Монголын ард түмэн нэн эрт үеэс оюун санааны илэрхийдэл болсон үлгэр домог, зүйр, сэцэн үгс болон аман зохиолоороо дамжуулан өөрийн философи буюу сэцлэх ухаанаа бүтээж, ирсэн билээ. Овог аймгийн соёлтой ертөнцөд бараг хаалттай байсан монголчууд Тэмүүжиний удирдлагаар дэлхий дахиныг соёл иргэншлийн тэсрэлтэнд хүргэж, грек, ромын гэгдэх түүхэнд өөрчлөлт оруулан хүмүүнлэг соёлын мэргэн ухааныг бүтээсэн юм. Монгол мэргэн ухаан нийт дорнын философийн нэгэн адил тухайн үндэстний урлаг, шүлэг яруу найрагтай хамт **хүмүүнлэг шинж чанартай сэцлэх ухаан (knowledge of wisdom)** болон боловсорч, нэн ялангуяа бичгийн хэл үүссэн цагаас эхлэн тайлбарлах философийн хэлбэрт шилжин хөгжсөн байна.

Нэлээд хожим монголчууд байнга соёлын харилцаатай явж ирсэн Энэтхэгийн эртний оюун ухааны дээдийг шингээсэн их хөлгөн судар болох

“Ганжуур”, “Данжуур”-ыг монгол хэлнээ хөрвүүлсэн нь манай философийн хүмүүнлиг агуулга, онолын үндсэн эх сурвалж, монголын буддизмын анхны өвөг утгыг нээн гаргах бичвэр болж өгсөн билээ. “Орчин үеийн шинжлэх ухаан «...эртний Энэтхэгийн дуун ухаан (оросоор лингвистика) сүрхий хөгжиж, Банини гэдэг Энэтхэгийн эртний хэл зүйчийн зохиосон хэл зүй, Дандин багшийн зохиосон яруу найргын толь гэдэг яруу найргын онолыг өндөр үнэлдэг» гээд «...үүнээ тэр Банинийн хэлний зүй, Дандин багшийн яруу найргийн толийг монголчууд төвд монгол хоёр хэлээр үзэн судалсаар хэдэн зуун жил болжээ»[1] хэмээн Ринчен багш дүгнэчихүй.

Төв Азийн нүүдэлч малчин монголчууд амьдрах ертөнцийн ажиглалт, туршлагын натур сэтгэлгээ, эртний мэргэн ухаанд түшиглэн сэцлэх (*philosophize*) арга зүйг гарган авдаг байжээ. Тэр үед нэгэнт бүрэлдэн тогтсон байсан монгол бичгийн хэлээр “сэцлэх ухаан” (*knowledge of wisdom*) гэж бүрэн зөв илэрхийлсэн ийм эргэцүүллийг дэлхий нийтээр философийн эргэцүүлэл (*philosophical reflections*) буюу сэцэн мэргэнд дурлах гэж нэрлэдэг. Үүнийг ямар нэгэн гүн ухаан, эсвэл гүехэн ухаан, үзэл санаа гэх мэттэй хольж хутган олныг төөрөлдүүлэх нь философи гэж юу болох, юу хийдгийг мэдэхгүйгээ л харуулж буй хэрэг. Сэцэн мэргэнд дурлах ухааныг тодорхойлж үлдээсэн манай монголын хамгийн эртний дурсгалт бичгийн нэг болох “Оюун түлхүүр”-т засаг цаазыг номын ёсоор барьж, олон амьтныг жаргаланд хэрхэн зохиож явах тухай сэцлэн хэлэлцэж ирсэн нь манай өвөг дээдэс философийг бусад шалгадаг ухаануудаас том, ерөнхий хэмээн ялган онцолж сэцлэх ухаан, эргэцүүлэн бодох урлаг, шүтэн барилдахуйг онох арга зүй хэмээн үзэж байсны гэрч мөн. Энэ нь философи бол эргэцүүлэхүй, хөөрөлдөхүй, мэтгэлцэхүй, сэцлэхүй ухаан мөн гэж үздэг уламжлалыг харуулах авай. Монголчуудын сэцэн мэргэнд дурлах гэнэн ухамсар нь нэг талаас, далдын хүч, ид шидийн итгэл үнэмшил (*magic*), агийн ёс (*mysticism*)-ны санаалаг юмс нөгөө талаас, амьдралын практик дахь бодисын материаллаг туршлагатай шүтэн барилдуулан мэргэн ухааныг бүтээж байв. Нийгэм, үйлдвэр болон шинжлэх ухаан зэргээс хол байгалиас ангижралгүй, түүнтэйгээ цуг шүтэн барилдаж олон мянган жил өнгөрөөсөн монгол угсаатны мэргэн ухаанд зөн билиг онцгой үүрэгтэй байжээ. Тэдний хувьд зөн билиг зурхай ид шидийн хүч (*magic*) зэрэг нь бодит байдлын жам ёсны нэг тал мөн тул мэргэн ухаан бүтээхэд заавал оролцдог байв.

III. Хэлэлцүүлэг

“Оюун түлхүүр” (*The Key to Intelligence*) нэрт *шастир*. XIII зууны үеийн Монголчуудын бичгийн хэл, урлаг уран зохиол, шүлэг найраг ба урьдах мэргэн ухааны уламжлалын томоохон бүтээл нэгэнт болсон байв. Харин үүнийг манай философичид дутуу мөчид ойлгож, тайлбарласаар ирсэн гэмийг эргэн үзэж, нөхөн засаж, залруулах шаардлагатай. Юуны өмнө, бараг судлагдаагүй үлдсэн философийн эргэцүүллүүд буюу оюун билгийн мэргэн ухааны үндсэн зүй тогтлыг шинээр ойлгож, Чингис хааныхаа өөрөө тодорсон гоц чанараас ургуулан орчин үеийн шаардлагатай холбон тайлбарлах ёстой. «Хүн төрөлхтний өмнө тулгарч буй шийдвэрлэх асуудалтай уялдуулан олон соёлын хүрээнд эртний болон эдүгээгийн сэтгэгчдийн философидох янз бүрийн хэлбэрийг бүрэн хамрахын тулд философийн судалгааг даяаршлах

зорилтыг»[2] дэлхийн философичдын XXIV конгресс дэвшүүлээ. Тогтвортой хөгжил рүү чиглэсэн үйлийн ёсны хүмүүнлэг философийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд философийн эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн, нийгмийн болон байгалийн шинжлэлийн салбар ухаанууд, эдийн засаг, нийгэм, улс төр, шашин, соёл, уламжлалын үйл ажиллагааны хэлбэрүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах зам хамгийн ашигтай байх болно.

Нэн эртнээс нааш даруй мянгаад жилийн турш Монгол үндэстний амьдрах ухаан болон хүмүүнлэг боловсрол, хүмүүжил, соёлын ерөнхий үндэс болсоор ирсэн гэж үзэх үндэстэй. “Оюун түлхүүр” шастир анх бичгээр боловсорсон тэр цагаас эхлэн Монгол оронд хамгийн олон хувилбараар хамгийн их дэлгэрч айл бүхний унших ном болж байсан тул түүний сургаал дахь боловсрол, хүмүүжлийн философи аман болон бичгийн хэлбэрээр хүн бүхэнд хүрч чадсан нөхцөл байдал юм. Бид энэ талаар академич Ц.Дамдинсүрэн зэрэг салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн хэл шинжлэлийн эрдэмтдийн дүгнэлтийг үндэс болгож байна. Тухайлбал, академич Д.Цэрэнсодном “Бидний ажигласнаар “Оюун түлхүүр” бол XIII зууны үеэс бидэнд уламжлагдан ирсэн зохиол биш юм. Учир юун хэмээвээс, энэ шастир гол төлөв Монгол оронд нэн эрт үеэс аман ба бичгийн хэлээр оршиж байсан хүмүүнлэгийн шинжтэй уламжлалт шүлгүүдийг өөртөө агуулж байдаг. Академич Д.Цэрэнсодном эдгээр нь “Панчатантра”, “Субашид” зэргийн эртний энэтхэг болон түвдийн сургаалт зохиолуудаас авсан эш сурвалжуудаар нэмж баяжсан байдаг билээ. Энэ бүтээлийг бичиг үсэгт суралцах сурах бичиг болгон ашиглаж иржээ. Энэ шастир дундад зууны Монгол оронд хамгийн ихээр түгэн дэлгэрсэн ном болоод зогсоогүй басхүү боловсрол, хүмүүжлийн зорилгод үйлчилж байсан юм”[3] гэж дүгнэжээ.

“Оюун түлхүүр” шастирын “Ажиглан, онож мэдээд Харин биеэ шүүгтүн”[4] хэмээх сургаал философийн төдийгүй ер бүх л шинжлэх ухааны үндсэн шалгуур болох юм үзэгдэл, түүний үндсэн зүй тогтол, алив баримтыг ажиглан судлах арга болон шалган нотлох туршилтыг үндэс болгосон гэдгийг зааж байна. Юм үзэгдэл болон алив баримтыг ажиглан судлаж, туршилтаар шалган нотлох нь эрдэм мэдлэгийг бүтээх шинжлэх ухааны зам билээ. Тэгэхлээр энэ сургаал, үйлийн боловсрол хүмүүжлийн үндэс нь эрдэм мэдлэг гэдгийг дам хэлж буй хэрэг. Эрдмээр тэтгэсэн бүхнийг боловсорсон, боловсон гэнэ. “Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн, Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун”[5] гэж сургасан нь амьдрах ухааны олон зууны туршлагаар шалгагдаж нотлогдсон хүмүүнлэг үйлийн боловсролын үндсэн агуулга, шалгуур үзүүлэлтийн илэрхийлэл мөн. Энэ сургаал боловсролтой хүн гэж боловсрол нь хэзээ ч төгсдөггүй хүнийг хэлдэг бөгөөд насан туршдаа боловсрох явцдаа хүн бүх талаараа оюунлаг, хүмүүнлэг чанартай болдог гэдгийг л зааж өгч байна.

“Оюун түлхүүр” шастир дахь үйлийн ёсны боловсрол, хүмүүжлийн сургаал, түүний онтологи болон гносеологи мөн чанарыг судлан шинжилж, он цагийн уртад үл тасалдах юм үзэгдлийн чинад зүй тогтлыг орчин цагийн хүний ахуйн шударга журамт үндсэн зарчим, ирээдүйн иргэний нийгмийн ёс зүйн үүрэг, хүний эрхэм чанар, үнэт зүйлс төлөвшихөд үзүүлэх эерэг нөлөө, ач холбогдолтой холбон тайлбарлах нь философийн хийх ажил мөн. Үүний тулд нэгд, уг сургаалууд дахь монголчуудын байгальтай шүтэн барилдаж зохицсон

ахуй, үйлдлийнхээ чинад хууль зүй тогтлыг мэдэгдэхүүн болгож хувиргадаг оюун санааны тулгуур, алсыг харж үйлийн үр дүнг эргэцүүлэх танин мэдэхүйн арга зүй, боловсрол, хүмүүжлийн үндэс нь заавал эрдэм ном байж ирсэн үнэлэмжийг харуулах. Хоёрт, нийгмийн ёс зүй, хүмүүсийн зан аалийн хэм хэмжээний хөтөлбөр болж ирсэн ёс журам, үйлдлийн үүргийн тухай монголын уламжлалт ойлголтын философийн утгыг сэргээн Кантын “категорик императив” сургаалтай харьцуулан тайлбарлах. Гуравт, монголчуудын ёс зүйн үнэт зүйлс, хэв ёсны үнэлэмжийн уламжлалыг орчин үеийн эрхэмлэлтэй холбон ойлгох. Дөрөвт, хүмүүний хувийн болон нийгмийн эрхэм чанар, нэр төр ба шударга ёсны тухай шастирын зарим санааны ач холбогдлыг тодруулах. Тавд, ёс зүйн үүрэг, харилцааны хэв ёс, журамт үүргийн асуудлыг шийдвэрлэсний ач холбогдлыг үзүүлэх хэрэгтэй юм.

Байгальтай шүтэн барилдах зохицлын тухай амьдрах ухааны мэдлэг, чадварын үндэсний уламжлал монголчуудын нэн эртний натурфилософид суурилж байсан нь хувь хүн боловсрол төлөвших үйлийн ёсны үзэл баримтлал (Pragmatic concept of education)-ын үндэс болж өгчээ. Энэ философи Монгол улсын тогтвортой хөгжил 2030” хөтөлбөрийн агуулгад шингэснийг энд онцлон тэмдэглэе. Сургаалын агуулга дахь хүмүүнлэг философи, үйлийн ёсны боловсролын ерөнхий зүй тогтол нь насан туршдаа өдөр бүхэн сурч боловсрох хувийн арга чадварыг дэмжихэд чиглэж байснаараа эдүгээгийн тогтвортой хөгжлийн үзэл санаатай нэгдэн нийлж байгааг тэмдэглэх нь чухал. Хүмүүс ба нийгмийн сайн сайхан амьдрал зөвхөн ухаан ба оюун шүтэлцсэн хүрээ, оюун мандлыг цогцлон бүтээх замаар хэрэгжих ёстойг оюун билгийн ухаан зааж байна. Ухамсар ба хүмүүний ахуйн ийм харьцаа өөрийн монгол философио даяаршлын эерэг үйл явцад нийлүүлэн тогтвортой хөгжилд шилжих замаар мэдээллийн нийгэм бүрэлдэх явцад хэрэгжих ирээдүйн оюун мандалд, зөвхөн сайн буянт үйлийн үр дүнд боломжтой болно. Түүнээс биш хүмүүнлэг үйлийн боловсролгүйгээс болж өдөр тутмын бэртэгчин амьдралд баригдаж, үл бүтэх мөрөөдөл, элдэв шашны мухар сүсэгт автсан зарим лам хувраг, бөө удган, эрдэмтэн докторуудын гоёмсоор илэрхийлэн хэлдэг шиг “Бумбын эрин эхлэхэд” юм уу, эсвэл “Майдар бурхан залрахад” л сайн амьдрал өөрөө хүрээд ирэхгүй. Эдгээр мунхаглалын эхнийх нь үл гүйцэлдэх үзэл, хоёр дахь нь шашны мухар сүсэг юм. Харин хүмүүс өөрийн үйлээ эрдмээр удирдуулж, ухаанаар шүүн хянаж, сайн буяныг үйлдэн муу нүглийг тэвчин “үйлээ туйлд нь хүртэл зүтгэж” баймаажин сайн нийгэм, сайхан амьдралыг өөрсдөө цогцлон бүтээж чадна гэдэг энгийн үнэнийг “Оюун түлхүүр” онгойлгож өгөх болно.

Хүмүүний ахуйн үндсийг тодорхойлогч үзэгдэх байдал ба үнэн бодит чанар хоёрын харилцан холбоог «...хэн хүмүүн хянан үзэж хэр хэрээ мэдэж, чинээ чинээгээ бодож явсан нь сайн” хэмээн сургасан нь “Эрдэнийн сан субашид” дахь эртний энэтхэгийн философи сэтгэлгээний ул мөрөөс эхтэй бөгөөд энэ санааг гүнзгийрүүлэн “Оюун түлхүүр” шастирт:

“Аяа! Гайхамшигт сайн үлгэр үүнийг

Танхай ард өөрчлөн (өөрийн биеэр, биечлэн) шалгаад

Сайтар ухааж (ойлгож) шүүвээс (шүүвэл)

Эдүгээгийн энэ цаг лугаа (цагтай) нийлэх”[6] хэмээсэн нь хүний эрхэм чанар бодгаль ба нийгмийн хөгжлийн нэг чухал хүчин зүйл төдийгүй, ерөөс

хүний дэг ёстой, зарчимч, журамтай ахуйн суурь үндэслэгээ болохыг хэлж өгч байна. “Оюун түлхүүр” шастирт бодгалийн ахуйн ёс зүйн тал түүний өөрийнх нь хувь чанарт тохирч байх тухай ерөнхий зүй тогтлыг гаргаж өгчээ. Тухайлбал:

“Арслангийн омог баатар мөн арсландаа зохино

Үнэгний уран арга мөн үнэгэндээ зохино

Арслангийн баатар омог үнэгэнд тус үгүй

Үнэгний уран арга арланд тус үгүй

Арслан үнэг мэт явбаас түргэн гутах

Үнэг арслан мэт явбаас түргэн үхэх”[7] хэмээн сургажээ.

Бодгалийн ахуй дахь ухаарал ба сэтгэл хоёрын диалектикийг зөв ойлгох нь үйлдэл дэх ёс зүйн үүргийг тодруулах философийн суурь дэвсгэр болж өгөх учиртай. Ёс журмыг биелүүлэхийн тулд эхлээд түүний шаардлагын онтологийн мөн чанар, танин мэдэхүйн шүтэн барилдахуйг таньж мэдэх нь чухал гэдгийг “Оюун түлхүүр” шастир дахь ёс зүйн сургаал зааж өгдөг. Тухайлбал, “Эрдэнэт хүний биеийг олсон тул Эрдмийг хичээн сурах хэрэгтэй” гэж буй нь ёс зүйтэй ахуйн шаардлага, хэм хэмжээний үндэс нь эрдэм мэдлэг бөгөөд ёс зүйтэй үйлдэхийн тулд эхлээд харилцааны тухай ухаарал ба билиг оюуныг тэргүүн зэрэгт тавьж байгааг хэрэг. Энэ нь ёс зүйн бодит асуудал хүмүүс ихэнхдээ өөрийн хүсч байгаа зүйлийг биш харин зөв гэж үзэж байгаа, үнэн зөв гэж мэдсэн үйлдлээ л хийх явдалд оршино гэх дүгнэлтэнд хүрсэн өрнө дахины ёс зүйн агуу сургаалыг үндэслэгч Кантын метафизик лугаа адил төстэй байна. Энэ нь монголчуудын ёс зүйн философи, гэрийн хүмүүжил нь сайн муу болон сайн муу явдлыг эхлээд танин мэдэж, “үйлдэхийн урьд эрдмийг хичээ” гэх зарчимд тулгуурлан явагддаг байсантай агаар нэгэн бус уу. Академич Б.Жадамба «...үйлийг бүтээж төрүүлж байгаа ажиллагааг, “нэгсэн өөрчлөхүйг, эргэцүүлэхүйг журамлан дагахуйг амьдрахуйн ухаан гэдэг». Энэ нь «үйлдэхүйг даган журамлахуй юм»[8] гэж дүгнэжээ.

Монголын нүүдэлч малчид ухаарлын чинад дахь үйлдлийн харьцангуй агуулгаас шалтгаалан алив юм, ажил хэргийн гол ерөнхий утга чанарыг урьдах ухаан, урьдаас мэдрэх зөн билигт тулгуурлан түргэн ойлгож, түүнд тохируулан “усыг нь уувал ёсыг нь дагана” хэмээх зан үйлийн хэм хэмжээний харьцангуй философийг баримталж ирсэн. Энэ нь өмнө дурдсан сайн талуудын зэрэгцээ эргэцүүлэн бодохуйг боогдуулж, дэвшил хөгжлийг саатуулагч сөрөг муу талтай ажээ. Үүний эхнийх нь үр бол танин мэдэхүйн нүгэлт үндэс болж байдаг **нүүдэлчний бэртэгчин ёс** мөн. Хүмүүнлэг ёсны боловсролыг хүний хувийн мөн чанартай холбон үзэж шинжлэх арга, шүүмжлэлт эргэцүүллийг XIX зууны үеийн сэтгэгч В.Инжаннаши бас хэрэглэж байлаа. Тэрбээр монгол хүний сэтгэлгээ, ааль араншинг Гумилёв абугайтай адил байдлаар тодорхойлж өгсөн нь одоо ч гэсэн онц ач холбогдолтой хэвээр байна. Үүнд: «...эдүгээх тогтсон энгийн зан нь, зүүн гэр нь баруун гэрээ муушаах ба өмнө муж нь хойт газраа басамжлах, дундад улс нь гадаад аймгаа доршоох, дээр агчид нь доор бүхий юүгээн дарлах нь энэ буюу»[9] хэмээжээ. Түүний судалгааны арга зүй нь өөрийгөө магтах бусдыг муулах хоёр хэгийдлийг даван гарч чадах хоосон чанарыг олж, танин мэдэхүйн дундад замыг барих монголын натур философи байв. Инжаннаши монгол хүний сэтгэлгээг чин шударгаар тодорхойлон бичсэн нь: «...Долдугаарт: хүний зан нь хэдүй чигч шулуун боловч сэтгэл нь атхагтай,

зан нь цухал, явдал нь цөлс, санаа нь битүү, Наймдугаарт: аж төрөх нь түгдэг тагдаг, харангуй буранхуй, хэлэлцэх нь хэрцгий догшин, оморхог бардам. Есдүгээрт: байдал нь болхи бүдүүлэг сүрхий муухай, явдал нь огт бод бат үгүй, тэнэг оморхог баахан байвч урт хол зүрх сөс үгүй, Аравдугаарт: хүч маш сайн бөгөөтөл, өнө удаан зориг тамиргүй. Арван нэгдүгээрт: ёслол дүрэм, цээр ичгүүр хэмээгчийг нэг мөсөн мэдэхгүй... Тэргүүн нэгэн худалч бардам цөлс итгэлгүй амьтан буюу»[10] хэмээжээ.

Чингис хааны мэдэгдэхүүн. Тэнгэр угсаат монголын сүнс, урьдаас мэдрэх зөн билиг, сэтгэл мэдрэмжийг эзэмшиж өөрөө тодорсон Тэмүүжин монгол сүнсний мэдэгдэхүүн (*phänomen*) байлаа. Арьяа гурван үндэстний нэг болох монголчууд тэнгэр огторгуйгаас бууж ирсэн домогтой Бүртэ чонын удмын Добу мэргэний хатан Алунгоо унтах гэртээ зүүдэлсэн нь, “цагаан гэрэл өрхний нүхээр орж ирээд алтан өнгөгэй сахиулсан хувилж хэвтэх тавцангийн хажуугаар нааш цааш явмуй. Алунгоо очиж сэрснээс хойш жирэмсэн болж гурван хөвгүүд төрүүлсний нэг бодгаль Бодончарын удмын Есүхэйн Тэмүүжин нийтийн тооллын 1162 онд мэндэлжээ. Орчин үеийн философийн тайлал зүйн шинэ онол(Hermeneutische Phänomenologie)-ыг бүтээгч Х. Г. Гадамер “*phänomen*” гэдэг ойлголтыг тайлбарласан Хайдэггериин тодорхойлолтыг хамгийн бүрэн зөв гэж үзээд өөрийн бүтээсэн философийн тайлал зүйн онол арга зүйд ашигласан байдаг. “*Phänomen*” хэмээх категорийг герман хэлээр “das Sich-an-sich-selbst-zeigende”[11] буюу “өөрөө өөрийгөө өөртөө үзүүлэгч” гэж тайлбарласан Хайдэггериин тодорхойлолтыг дэлхий нийтээр нэгэнт хүлээн зөвшөөрчээ. “*Phänomen*” хэмээх ойлголтын “фә” гэдэг үндэс нь өөрөө тодрох чадвартай, өөрийгөө асууж буй ямар нэгэн зүйл, “гэгээ” “гэрэл”, “ил тод” гэсэн утгатай тул үзэгдлээс ангид өөрөө тодордог гоц чанар бөгөөд түүнийг ухаанаар бус харин оюун билгийн арга зүйгээр тайлж болох амуу.

Философид нэгэнт судлагдахуун болж, нэрлэгдсэн юм, үзэгдлийг ноумэн (noumen) гэж, харин ухамсрын эргэлтэнд ороогүй ямар нэгэн юм байгааг зааж байгаа дохиог феномэн “*phänomen*” гэж ялгасаар ирсэн амой. Монгол сэтгэлгээ соёлын түүх, философийн тайлал зүйн тайлбар толь болох “мэргэд гарахын орон хэмээх тогтоосон дияг” бол “буддын таван ухааны “нэр, дохионы нэрийтгэлийг нэрийтгэхүй ёсныг цаазлан тогтоож”[12], монгол хэлэнд зөв орчуулах дүрэм, заавар болж ирсэн билээ. Энэ толь бичигт ямар нэгэн юмны өөрөө тодрох гэгээ, дохиог “мэдэгдэхүүн” хэмээн журамласан байдаг. Манай нэрт философич З. Агваанбалдан “мэдэгдэхүүн нь хоёр үнэний ялгалын суурь мөн бөлгөө. Орчлонд орох, эгэхээс хамаарваас тэр хоёроос олон хэрэггүй, тэр хоёрын аль нэг үгүй бөгөөс үл хураагдахын учир мэдэгдэхүүн янагуух хийгээд үнэмлэхүй үнэн үүнээ барагдмуй”[13] гэж тодорхойлсон. Академич Ш.Лувсанвандан үг нь бодит ертөнцийн юм, үзэгдэл, чанар, хөдөлгөөнийг нэрлэсэн, заасан буюу асуусан дохио байна гэж үгийн гол мөн чанарыг гаргаад “үгэлбэрийн дотор биеэ даасан мэдэгдэхүүний дохио болж чадах нэг буюу хэдэн морфемоор бүтсэн нэгжийг үг гэж үзэж байна”[14] хэмээн дүгнэжээ.

Талын нүүдэлчдийн анхны төрт улсыг байгуулсан Хүннү өвөг дээдсээс эхлэн хойш улирч угаас заяах тавилантай агуу хүчирхэг эрх мэдэл өөрөө тодрох гайхамшигт агшин, Тэмүүжин монголын сүнс өөрийгөө сануулах нууцлаг дохио гэгээ болж төрсөн гэж тайлж болно. Тэмүжиний мэдэгдэхүүний бэлгэ

билгийн гоц чанар юуны өмнө, түүний тэнгэрээс заяат гэдгээр тодорхойлогдож байна. Үүнийг тайлбарласан манай болон гадаадын эрдэмтэд ихэнхдээ европ төвт үзлийг дагалдан тэнгэрийг бүхнийг бүтээгч дээд хүч болох бурхантай холбон тайлбарлаж иржээ. Монголчуудын нэн эртний мэргэн ухааны баримтаас үзэхэд энэ нь огт өөр үндэслэлтэй бөгөөд амьдралаас урган гарч эрүүл ухаанаар өдөр бүр шалгагдан нотлогдож, мэргэн ухаан болж өвлөгдөж ирсэн монголын натур философиор тайлагдах учиртай. *Орчлонгийн бүхэллэг чанарыг таньж мэдэх оролдлого, тайлал нь манай уламжлалт сэтгэлгээнд хүн байгаль хоёрын барилдлага, байгалийг ойлгох нь хүний гэгээрлийн суурь үндэс мөн гэх натурфилософийн үзлээс*[15] *эхтэй байсан. Монгол сэтгэлгээ, соёлын салшгүй бүрэлдүүн болж нэгэнт хэвшсэн Буддын философийн бэлгэ чанар ертөнц бүхэлдээ хүнээс шалтгаалан нөхцөлдөж, шүтэн барилдаж байдаг, бүх оршигч, түүний дотор хүн өөрөө байнга эрч хүчтэй өөрчлөгдөгч (анитья) шинж чанартай гэж баталдагт оршдог.*

Монголын эртний мэргэн ухаан хүмүүний ахуй нь орчлон ертөнцийг үзүүлэх боломж бус харин түүний нөхцөл мөн тул бүхнийг бүтээгч бурхан биш харин хүмүүс ахуйгаа ухамсартайгаар бүтээж, өөрийн оршихуйнхаа төлөө сэтгэл зовж, хариуцлага хүлээж байх боломж олгох ёстой гэж үздэг байв. Энэ нь Орчлонгийн орон ба хугацаан дахь үндсэн дөрвөн махбод, бүх юм үзэгдлийг нийлбэр цогцод нь авч үзэх (*Metaphysics-Cosmology*)-д суурилсан жам ёсны шүтэн барилдахуйн хууль (*The law of interdependence*)-ийг зөв ойлгож даган баримталж байсныг харуулж байна. Энэ нь бас оршихуйн тав дахь махбод болох “огторгуй”-н арга зүйн өргөн боломжтой холбоотой бүлгээ. Монголчууд тэнгэр гэдэг ойлголтын цаана нарны аймаг тэргүүтнийг бүгдийг багтаасан нууцлаг Орчлон огторгуй байх бөгөөд тэрхүү “хязгаараас нөгчигсөн хоосон чанар”-ын шүтэн барилдахуйн үндсэн зүй тогтлыг энэ дэлхийн жам ёстой холбон тахиж шүтдэг байсан гэж дүгнэж болно. Орчлонгийн жам ёсны түгээмэл энэ зүй тогтлыг Чингис хааны тэнгэр шүтэх шүтлэгийг илэрхийлсэн овог аймгийн тамга, тухайн үеийн мөнгөн зоосон дээр барласан онгин тэмдэг гэрчилж өгнө. Морин эрдэнийн шим сүүний дээжийг “...эрхт тэнгэр энэ дэлхийд өргөн тахиад үүнээс эхлэн сайтар тогтоож бүрэн энэ монгол улсад хууль болгосугай”[16] гэж Чингис хаан зарлиг буулгасан байдаг.



Орчлонгийн жам ёсны хууль, огторгуйн хоосон чанарын дохио, тэнгэр шүтлэгийн тэмдэг онгин тамга

Чингис хаан Хорезмын хаант улсыг байлдан эзэлсний дараа 1221 онд Самарканд хотноо дэлдүүлсэн нэгэн зоосон дээр “*Чингис хаан. Чингис хааны мөнгө. Самарканд 1221 он*” хэмээн арабаар бичээд энэхүү онгин тамгыг сийлсэн байдаг.

Нэрт эрдэмтэн Х.Пэрлээ гуай “Монгол түмний гарлыг таамгаар хайж судлах нь” хэмээх алдарт бүтээлдээ энэ тамгыг “онгин буюу наран” тамга бөгөөд эртний монголын хиад угсаатны овгийн

тамга гэж дүгнэсэн байдаг. Ийм тамга одоогийн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дахь Биндэр уулын Рашаан хадны дэргэдэх чулуун самбарт дүрслэгдсэн 200 гаруй тамга тэмдгийн дотор тэргүүн эгнээнд байдаг.[17]

Тэнгэр гаралтай тул Орчлонгийн жам ёсны хууль, огторгуйн зарчмыг дээдлэх энэ үзэл манай өвөг дээдэс Хүннүчүүдэд байсныг түүх археологийн сүүлийн үеийн судалгаа батлан харуулж байна. Архангай аймгийн нутгаас олдсон Хүннүгийн эртний нийслэл “Луут хот”-ын сууринаас олдсон вааран дээр орхон бичгээр “тэнгэрийн хөвгүүн Шанью” гэсэн бичээс байгаа нь үүний гэрч. Дээр дурьдсан Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэрьяа уулын “Аршаан хад”-ны орчмын чулуун дээр мөн орхон бичгээр бичсэн “эцэг минь Шанью гэж алдаршсан” нэг мөр бичээс гэж сонгодоогоос өмнөх уйгаржин бичгээр, “Чингис хаан” гэж цохисон дурсгал байдаг нь Чингис хаан өмнөх түүхээ сайн мэддэг, урьдах ухааны мэдлэг, эртний мэргэн сэтгэлийн мэдэгдэхүүнийг залгамжлан авсан байсныг илтгэж байна. Доссон сүнсний тухай монголчуудын уламжлалт үзлийг “...азийн умар дахь нүүдэлчин үндэстэн буюу зэрлэг үндэстэн нэгэн үл үзэгдэх сахиус байна гэж үздэг бөгөөд үүнийгээ тэнгэр гэдэг. Архиар сацал өргөж хурмаст тэнгэр ба дэлхийгээ тахьдаг” гэж тэмдэглэсэн байдаг[18].

Онгин наран тамганы тэмдгийн хүртэхүйн чинад далд утга, үндсэн чиглүүлэгч чанар бол монголчуудын сүнс өөрийгөө ухамсарлан улмаар огторгуйд гэгээ болон тодорч, үндэстэн мандан бадрахын дохио тэмдэг болж чадсаныг тэмдэглэсэнд оршино. Орчлон төрөх түрдэхүйн жам ёсны хуулийн анхны гэгээ, манан буданцарын мэдрэмж, дохиог эртний мэргэн ухааныг уламжлан мэдэх онцгой хүчтэй хөгжсөн зөн билгийн тусламжтайгаар ойлгож мэдсэн тул Тэмүүжин огт оргуйн мэдэгдэхүүн (*phänomen*), тэнгэр гаралтай хүмүүн болж чадсан гэж үзэж болно.

“Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир”-ын яруу найраг шударга бөгөөд энх амгалан амьдралын гол зарчмуудын тусгалыг өөрөө задлан шинжлэх явдал гэж ойлгосон Чингис хааны философийг анх гарган харуулжээ. Энд “өнчин хөвгүүн” найр наадам, архи дарсны хор уршиг ба ашиг тусын тухай амьдралын тусгай, онцгой мэдлэгүүдээс шүтэн барилдахуйн нэг учрал болох диалектикийн ерөнхий зүй тогтлыг зөв гаргах философийн арга болох **тусгай онцгойгоос ерөнхийг таамаглан гаргах арга (Hypothetical - inductive method)**-ыг хэрэглэсэн байдаг. Сонгодог бичгийн хэл, утга зохиол дээр суурилсан нүүдэлчдийн монгол философи үүсэх нь энэхүү сэцлэх (*philosophize*) ажил, арга зүйгээс эхтэй. Тэмүүжин Өүлэн эхээс мэндэлж “төрсөн цагт Дэлүүн Болдоогоос цагаан гэрэл сацрав. Онон мөрөн гурван өдөр тунгалаг урсав. Хоёр гартаа нөж атган төрсөн”[19] “гартаа цус атгасан нь улаан чулуу адил”[20] гэх домог нь философийн тайлал зүйн үүднээс зөвхөн монголчуудын хүсэл мөрөөдлийн төсөөлөл төдий бус харин монгол сүнсний өөрийн ухамсрын биелэл, агуу хүчирхэг эрх мэдлийг эзэмшиж, хэрэгжүүлснээр дэлхийн түүхийг өөрчилж чадах онцгой увдист гоц хувь хүн өөрөө бодитойгоор тодорснийг урьдаас ухаарсан мэдрэмж, сэтгэлийн тэмдэг, метафора (метафорá) байлаа.

Тэнгэр заяат хөвгүүн Тэмүжин урьдах ухаан, ирээдүйг мэдрэх зөн билиг, эргэцүүлэн бодох саруул эрдмийн билэг билгийн их хүчээр “...гучин жил зовж зүдэж зүтгэсээр арай гэж хойт улсыг хурааж олон самууныг арилгаад, Бат улсын нэгэн гэр бүлд гучин зургаан их улс, далан хоёр бага аймгийг нэгтгэн нэгдмэл улсыг байгуулж, үндэстэндээ амар амгаланг авчирсаны дээр гадаад энх амгаланг тогтоохын тулд ойрхи өрнөдөөс заналхийлсэн лалын ертөнцийг

нугачин дарж, Европын цэрэг армийг бут цохихдоо ухаалгаар хэрэглэж ирсэн билээ. Нэг бумаас хэтрэхгүй дайчидтай байсан Монголын их цэрэг Чингис хааны удирдлага дор Ромчуудын дөрвөн зууны туршид эзэлснээс ч уудам их газар нутаг, хүн амыг 25 жилийн дотор байлдан дагуулсан юм.

Чингис хаан Хэрлэн мөрөнд нутаглаж бүхийд (1211 оны) зуны тэргүүн сард түшмэддээ зарлиг болруун: “Манай монголын гэжээсэн мал нь хэдэн зүйл буй боловч өшт дайсан лугаа байлдахад нөхрийн дээд, үлдэх дайсныг даруй түргэн гүйцэгч үл алдагч хавт баатруудын жигүүр, өсөх залуусын биеийн чимэг болсон эрдэнэ, морины шим сүүний дээжийг эрхт тэнгэр дэлхийд өргөн тахиад үүнээс эхлэн сайтар тогтоож бүрэн энэ монгол улсад хууль болгосугай хэмээгээд, есөн өрлөг, таван тайж тэргүүлэн ер таван өнгө дөрвөн харь улсаа хурааж их хурим хийхэд”[21] сэцлэх ухаанаа уралдуулсан байдаг. Чингис хаан энэ харилцан яриандаа адуу малын шим сүүний дээж архи дарсыг эрхт тэнгэр дэлхийд өргөн тахиж ерөнхий зарчим болон ашиг тус ба хор уршгийн тухай тусгай онцгойн харилцаагаар үнэн ба шударга ёсны тухай, түүнийг хаанаас яаж олох, түүнд тохируулан хэрхэн амьдрах тухай асуулт дэвшүүлэн тавихын хамт үнэн бол хүн бүхэнд, бүр “өнчин хөвгүүн”-д ч өөрт нь байдаг бөгөөд харин бусадтай хамтран хэлэлцэх замаар түүнийг гарган сэцлэх(philosophize) боломжтойг харуулсан амой.

“Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир” хэмээх шүлэглэсэн найргийн философийн гол цөм нь монголын сонгодог бичгийн хэлээр “нүүдэлчдийн үйл хөдлөлийн төдийгүй сэтгэлгээний салбарын амьдрал үйл ажиллагаанд тогтсон үлгэр жишээг тусган харуулах өв уламжлал байсан”[22]. Эндээс үзэхэд, Чингис хаан хурц ухаантай төдийгүй эргэцүүлэн бодох чадвартай, бусадтайхарилцан ярилцахдаа аливааг гүн ухаж, уран илэрхийлж чаддаг хүн байжээ. Тэрбээр нарийн түвэгтэй бөгөөд ярилцагчаа сандралд оруулан уг асуудлаа өөрийн хүслийн эсрэг дахин дахин эргэцүүлэн бодоход хүргэх хүнд асуултыг эвтэйхэн тавьж чаддаг нь эндээс харагдана. Түүнтэй харилцан ярилцагчид нь мэргэн ухаант өрлөгүүд ба нэрт ноёд байсан тул тэднийг хаантан нарийн түвэгтэй асуултаараа хэрхэн будлиулж, өөрсдийгөө тэнэг мэт харагдуулахад хүргэж байгаа нь үнэхээр сонирхолтой. Чингис хаан чухам ийм маягаар хэн бугай ч гэсэн өөрийн хэлж буй үг, хийж буй үйл, амьдралаа асуулт тавих аргаар шүүмжлэлтэйгээр задлан шинжилж, эргэцүүлдэг философийг бүтээжээ. Үнэн ба шударга ёсны зарчмуудыг улам илүү гүн гүнзгий ойлгохын тулд асуулт тавих ба хариулах үйл явцыг ашиглахыг орчин үеийн философид диалектик арга гэж нэрлэдэг.

“Аргасун хуурчийн домог”. Монголын худам бичиг сонгодог хэлбэрээ олж байсан XIII зууны эхэн үеэс бидэнд уламжлагдан ирсэн философи, яруу найргийн цөөхөн дурсгалын нэг нь “Аргасун хуурчийн домог” хэмээх шастир юм. Чингис хаан сартуул иргэнийг дайлан эзэлсэн үе буюу 1222 онд бүтээгдсэн гэж үздэг “Аргасун хуурчийн домог” хэмээх энэ найраглалд сэцэн найрагч, хөгжимчин Аргасун хуурч ба Чингис хаан, түүний хүүхдүүдийн харилцан яриа (dialogus), хэлэлцүүлэг(discursus)-ийг шүлэглэсэн хэлбэрээр илэрхийлжээ.

Сократ анхдагч нь гэдэг харилцан ярианы ийм хэлбэрийг европын философийн эхлэл хэмээн үздэг байр сууринаас үзвэл энэ найраглалд сэцэн найрагч, хөгжимчин Аргасун хуурч ба Чингис хаан, түүний хүүхдүүдийн

харилцан яриа (dialogus), хэлэлцүүлэг(discursus)-ийг шүлэглэсэн хэлбэрээр илэрхийлжээ. Харилцан ярианы явцад гуравдагч шүүмжлэгч буюу бие даасан шинжээч (Independent expert) болох “аргасун хуурч”-ийг оруулж, тэр нь заримдаа ухахуйяа бэрх утгын хүндээр их хаан болон түүний мэргэн түшмэдийг сөхөөж, асуудлыг шүүн хэлэцүүлж байгаа нь энэ шастирт философийн эргэцүүллийг олон нийтийн хэлэлцүүлэг (discursus) болгож байна гэж үзэх гол үндэслэл мөн.

“...Арга билгийг чинь сурнам билээ.

Алиа муу аашаа эс олдом билээ

Арзанд эндсэн минь унэн...” гэх мэтээр “аргасун хуурч” алдаа оноогоо хүлээн зөвшөөрч, хааны “арга билгээс” сурч “шударга үнэнч” байхаа амлаж байна.

Энэ ертөнцөд байгаа ямар нэгэн юм ба өгүүлбэрүүд хоорондын харилцааг философийн тайлал зүй (Hermeneutic-херменойтик) буюу тэмдэгт ухаанаар задлан шинжилбээс, дараах тайлбар гарч ирнэ. Тайлал зүйн үүднээс энэ нь ярьж буй хүний бодол санаа, Орчлонгийн жам ёсны зүй тогтлыг ухамсарласан Монгол сүнсний илэрхийлэл юм. Тийм учраас өгүүлэгч “аргасун хуурч” бодол санаагаа нууж далдалсан тул эхний удаа ойлгоход бүх хүнд хэцүү байна. Шастирт “эзэн эс ухаж, бас өгүүл хэмээв” гэжээ.

“Алд биеэ амс хэмээвээс Аху төр минь алдууртузай.

Бутэн биеэ амс хэмээвээс Бурэн улс минь сандруузай.

Алд бие минь алжааваас алжаатузай.

Аху төр минь буу алдартузай

Бутэн бие минь зовбоос зовтузай.

Бурэн улс минь буу сандартузай...” хэмээн зарлиг болов.

Чингис хаан “ахуй төр” гэдэг ойлголтыг хэрэглэхдээ зөвхөн “байгаа” төрийг хэлээгүй харин өөрийнх нь ухамсрыг дамжиж, сэтгэл бодлоор нь бүтээгдсэн Орчлонгийн жам ёсны зүй тогтлын Монгол сүнс, зөн билигийг багтаан ойлгож байна. Шүлэглэж эцэн мэргэнээ илэрхийлэх нь нийт дорно дахины нэгэн адил монголын хүмүүнлэг соёлын уламжлал билээ. Нүүдэлчин монголчуудын хүмүүнлэг соёлын оюуны суурь үндэс нь тэдний аман ба бичгийн хэлээр илрэх Орчлонгийн жам ёсны зүй тогтлын сүнс, зөн билиг байлаа. Тайлал зүйн мэдэгдэхүүний билиг бол “...зарим талаар юм. үзэгдлийг “шууд барьж авах” гэнэн боломжийг үгүйсгэж, бид бүх зүйлийг манай хэл ба туршлагын үүднээс зайлшгүй тайлбарлах ёстойг баталдаг”. Бид өөр хүнийг ойлгох гэж оролдохдоо өөрийн хувийн урьдач санаа бодлоо эргэн харж цэвэрлэн хэн нэгэн хүний туршлагаа тодорхойлсон бичиглэл ба өөрийн эргэцүүлэл хоёрын хооронд урагш хойш байнга хөдөлж, үйл явдлын энэ эсрэгцэх хамаарал (диалектик) харилцан үйлчлэл, гүн увдисын бясалгалыг ойлгож тайлбарлах гэж хичээдэг билээ. Энэ үүднээс, шүлэглэсэн шастирын философийн гол цөм нь монголын сонгодог бичгийн хэлээр нүүдэлчдийн үйл хөдлөлийн төдийгүй сэтгэлгээний салбарын амьдрал үйл ажиллагаанд тогтсон үлгэр жишээ, юм үзэгдлийн түгээмэл зүй тогтлыг тусган харуулах өв уламжлал байжээ. Тэгэхлээр, тайлал нь хүмүүнлэг соёлын суурь болж өгсөн монголын сонгодог бичгийн хэлний хуулинд үндэслэн өгүүлэн буй шастирын бичвэрийг бүхэл бүтэн баримтат чанар, түүхийн ажил гэж үзэх онолын чиг хандлагаар

тодорхойлогдоно. Үүнийг ойлгохын тулд “...урлагийн туршлага ба түүхэн өгүүлэмжийг эх сурвалж болгон тайлал зүйн мэдэгдэхүүнийг бүтэн утгаар нь харуулах ёстой. Өөрөө тодорч буй энэ мэдэгдэхүүнд философийн хувьд үндэслэгдэх төдийгүй өөрөө бас философдох арга чадвар болж өгөх үнэний туршлага бий гэдгийг хүлээн зөвшөөрөх..[23] хэрэгтэй.

Ахуйг байж байгаа юм гэж, эсвэл тодорхой бүтэц хэлхээ холбоогүй олон юмны нэгдэл ч гэж тодорхойлох хэрэггүй гэдгийг Хайдэггер эш болгодог. Бидний амьдардаг ертөнц бол утгын хэлбэртэй харилцаануудаас бүрдэх харилцаа маягийн сүлжээс (Beziehungsflecht) амой. Чингэж үзэхүл, алив судалгаа жинхэнэ ёсоор мэдэгдэхүүний билигийн шинжтэй байхын тулд ямар нэгэн Парадигмтай хамт эхэлдэг байж болохгүй. Учир юун хэмээвээс, мэдэгдэхүүний билиг юмсын төлөв байдлыг дедуктив биш гэж үзээд ухаарлын чинад тайлбарлахыг оролддог. Хүн тэнд үргэлж ертөнцөд амьдарч, ойлгохуйн энэхүү өгөгдсөн хаяалбарын чинадаас эргэн ирж чадахгүй бөгөөд зөвхөн түүнийг ойлгох, зарим тусгай тал, хандлага, агшныг нээн илрүүлж тодотгож чаддаг байнам. Үүнийг тайлал зүйн хүртэхүй хэмээхүй.

Сэцлэх ухаан бол ахуйн суурь үндсэн зарчмууд, Орчлонд хүмүүний эзлэх байр суурь дахь янагуухуй, үнэмлэхүйг тийн ялгаж, буй үгүйн үүднээс мөнхдөх тасархайдах хоёр хэтийдлийг тэвчээд үнэнийг олох шалгууртай, юмны шинж чанар, зүйл ялгаа, жишээ сэлтийг нарийн гаргаж, маргаан мэтгэлцээн дунд ерөнхий зүй тогтлыг баталж, нотолж өгдөг арга зарчимтай билээ. Тийм учраас, энд **тусгай онцгойгоос ерөнхийг таамаглан гаргах арга** (Hypothetical-inductive method) хамгийн чухал байдаг. Энэ үүднээс үзэхүл шастир дахь хэлэлцүүлэг нь монголын нүүдэлчдийн ахуйд ард түмэн ба засаг баригч хааны үүрэг оролцооны харилцан хамаарал (диалектик), арга ухаан ба билиг ухааны тухай, тэдний харилцааны түгээмэл зүй тогтлын тухай философийн эргэцүүлэл болж чаджээ.

IV. Судалгааны үр дүн

Энэ шинжлэл урьдаас мэдрэх зөн билиг, Орчлонгийн жам ёсны хуулийн урьдах ухааны мэдлэг, сэтгэл мэдрэмжийг эзэмшиж өөрөө тодорсон Тэмүүжин монголчуудын сэргэн мандах сүнсний өөрийн ухамсар хүмүүни гоц чанар мэдэгдэхүүн (*phänomen*) болж чадсаныг бичгийн хэлний дурсгалуудыг философийн тайлал зүй, мэдэгдэхүүний билгийн ухаанаар батлахыг оролдсон. Энд шинжилсэн бичгийн дурсгалуудад урлахуйн ухаанаар харуулсан шинжлэх ухааны аргаар танин мэдэж чадахааргүй бөгөөд философийн ач холбогдолтой түгээмэл зүй тогтол, үнэн ба шударга ёсны зарчмуудыг гарган харуулахыг хичээсэн. Монгол философи Чингис хааны хувьд алив юм, үзэгдэл, ажил хэргийн гол ерөнхий утга чанарыг урьдах ухаан, амьдралын туршлага, уламжлан мэдрэх зөн билиг, гүн увдисын дотоод бясалгалд тулгуурлан түргэн ойлгож, өөрийгөө танин мэдэх, Орчлон ертөнцийг зөв тайлбарлан тусгай онцгойгоос ерөнхийг хийсвэрлэн гаргах эргэцүүлэл, харилцан яриа, егөөдөл, хэлэлцүүлэгээр илэрч, сэтгэлгээ ба үйлийн шударга үнэн суурь зарчмуудын ухаарал болж байжээ.

Ашигласан материал

1. Ринчен Б. (1963). Галидаса. Үүлэн зардас. Уб., 8 дахь тал
2. The XXIV World Congress. (2018). Beijing, China.
3. Цэрэнсодном Д. (2017). Истоки и своеобразие письменной поэзии Монголов эпохи средневековья. Улан-батор, 18 дахь тал
4. Оюун түлхүүр нэрт шастир оршвой. (2007). Уб., 25 дахь тал
5. Оюун түлхүүр нэрт шастир оршвой. (2007). Уб., 20 дахь тал
6. Оюун түлхүүр нэрт шастир оршвой. (2007). Уб., 31-32 дахь тал
7. Мөн тэнд. (2007). Уб., 27 дахь тал
8. Жадамба Б. (2017). Амь амьдрахуй ухаан. Уб., 51 дэх тал
9. Инжиннаши В. (2009). Хөх судар. (Тэргүүн дэвтэр). Уб., 75 дахь тал
10. Инжиннаши В. (2009а). Хөх судар. (Тэргүүн дэвтэр). Уб., 63 дахь тал
11. Heidegger, M. (2006). Sein und Zeit. Niemeyer, Tübingen., Auflage. p. 43
12. Жамъянтүвдэн. (1988). Мэргэд гарахын орон. 19 дэх тал
13. Агваанбалдан З. (2017). Хаврын охин тэнгэрийн тогтсон тааллын ёсны янагуух, үнэмлэхүйн утгыг номлосон сайн номлол оршвой. Философийн хүрээлэн, ШУА. Уб., 96 дахь тал
14. Лувсанвандан Ш. (1999). Орчин цагийн монгол хэлний бүтэц. Дэд дэвтэр. Уб., 98 дахь тал
15. Өлзий Тү. (2010). Эртний монголчуудын экологийн соёл сэтгэхүй. (Худам бичгээр). Хөх хот, Өвөрмонгол, БНХАУ. Багшийн их сургуулийн хэвлэл. 26-38 дахь тал
16. Дамдинсүрэн Ц. (1959). Монгол уран зохиолын дээж зуун билиг оршивой. Уб., 39-43 дахь тал
17. Пэрлээ Х. (1976). Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. ШУАХ. Уб.,
18. Доссон. (1991). Монголын түүх. Хөх хот, Өвөрмонгол, БНХАУ. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 36 дахь тал
19. Инжиннаши В. (2009). Хөх судар. Дэд дэвтэр. Уб., 331 дэх тал
20. Чингис хааны өв соёл. Чингис хааны хураангуй шастир. Боть III. (2021). Уб., 31 дэх тал
21. Дамдинсүрэн Ц. (1959). Монгол уран зохиолын дээж зуун билиг оршивой. Уб., ШУАХ. 39-43 дахь талууд
22. Ринчен Б. (1958). Из нашего культурного наследия. Уб,
23. Hans-Georg Gadamer. (2011). Wahrheit und Methode (Klassiker Auslegen) (German Edition) Paperback. p.70